



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/78/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Аудитор: Д.Балжинням
Утас: 99435309
цахим хаяг: D.Baljinnyam@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Б.САНДАГСҮРЭН ТАНАА

2023.02.20 № 02/78.
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлагын хэрэгжилтийг ханган ажиллаагүй, байгууллагын чиг үүргийн бус үйл ажиллагаанд шатахуун олгосон, Хөшөөт хөгжил сангийн батлагдсан хөтөлбөр арга хэмжээний зардлаас үндсэн үйл ажиллагааны зардал санхүүжүүлж батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулаагүй, Засгийн газрын тогтоолын хэрэгжилт ханган ажиллаагүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуй нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Засгийн газрын 404 тоот тогтоолоор "ИТХ-ын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах" журамд заасан заалтуудтай тус тус нийцээгүй байна. газрын 404 тогтоолын 3 дугаар хавсралтаар "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын заалтуудтай тус тус нийцээгүй, "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт онцлох ажил гүйлгээ байхгүй болно.

021020200

Аудитын гол асуудал

ИТХ-ын үйл ажиллагааны чиг үүрэгт хамааралгүй иргэдийн хуралд суудалтай намуудад санхүүгийн дэмжлэг олгох санхүүжилтийг бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн дансанд баталж өгч байгаа нь төсвийн төслийн шаардлага, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн, тухайн байгууллагын санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ болж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт, 45 арга хэмжээг батлан хэрэгжилтийг хангаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 41 төлөөлөгч, 17 сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 371 төлөөлөгч, 91 багийн ИНХ-ын 503 идэвхтэн сонгуультаан тус тус үйл ажиллагаагаа бүх шатны нутгийн захиргааны байгууллагуудтай уялдуулан Хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>17,935,438.00</u>	<u>19,270,090.01</u>
33	АВЛАГА	175,806.00	131,958
335	Бусад авлага	175,806.00	131,958
3351	Байгууллагаас авах авлага	175,806.00	131,958
35	БАРАА МАТЕРИАЛ	17,759,632.00	19,138,132.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	330,000.00	1,400,000.00
354	Хангамжийн материал	17,429,632.00	17,738,132.00
35420	Аж ахуйн материал	1,071,334.00	1,071,334.00
35470	Бусад хангамжийн материал	16,123,298.00	16,666,798.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>97,121,376.53</u>	<u>77,891,688.31</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	97,121,376.53	77,891,688.31
392	Биет хөрөнгө	97,121,376.53	77,891,688.31
39203	Авто-тээврийн хэрэгсэл	124,746,100.00	124,746,100.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-124,746,100.00	124,746,100.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	91,580,127.00	91,580,127.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-57,115,972.45	-68,995,918.83
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	66,458,059.00	66,458,059.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-41,880,837.02	-49,230,578.86
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	38,055,000.00	38,055,000.00
39217	Ном	25,000.00	25,000.00
39301	Програм хангамж	1,050,000.00	1,050,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,050,000.00	-1,050,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>115,056,814.53</u>	<u>97,161,778.32</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,200.00</u>	<u>3,674,822.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,200.00	0,0
413	Өглөг	2,200.00	0,0
4136	Бусад өглөг	2,200.00	0,0
41361	Байгууллагад төлөх өглөг	2,200.00	0,0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>115,054,614.54</u>	<u>97,161,778.32</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	115,054,614.54	97,161,778.32
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	169,177,150.00	169,177,150.00
51101	Өмч: - төрийн	169,177,150.00	169,177,150.00
512	Хуримтлагдсан үр дүн	-54,122,535.46	-72,015,371.68
51210	Өмнөх үеийн үр дүн	-54,122,535.46	-54,122,535.46
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-17,892,836.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>115,056,814.54</u>	<u>97,161,778.32</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	600,710,200.00	1,252,217,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	600,710,200.00	1,252,217,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	124,325,600.00	735,336,000.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,500,000.00	526,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,700,000.00	208,700,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	636,000.00
1330	Төсвийн захирагчдаас	476,384,600.00	516,881,900.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	476,384,600.00	516,881,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	617,247,108.31	1,270,110,736.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	617,247,108.31	1,270,110,736.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	591,329,942.31	1,264,163,885.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	181,436,279.00	594,852,461.00
210101	Үндсэн цалин	136,864,594.00	137,640,100.00
210102	Нэмэгдэл	38,415,685.00	32,727,990.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,156,000.00	5,426,000.00
210104	Урамшуулал	00.00	419,058,371.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,560,688.00	22,664,055.00
210201	Тэтгэврийн даатгал	16,306,952.00	15,556,213.22
210202	Тэтгэмжийн даатгал	1,813,434.00	1,830,142.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,450,748.00	1,464,114.17
210204	Ажилгүйдлийн даатгал	362,687.00	346,689.37
210205	Эрүүл мэндийн даатгал	3,626,867.00	3,466,895.53
2104	Хангамж, бараа материалын зардал	26,057,243.00	24,515,394.00
210401	Бичиг хэрэг	1,740,431.00	1,445,400.00
210402	Тээвэр, шатахуун	17,661,000.00	16,685,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,039,112.00	5,771,544.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	196,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	416,700.00	416,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,802,900.00	1,409,500.00
210604	Урсгал засвар	1,802,900.00	1,409,500.00
2107	Томилолт, зочны зардал	6,122,200.00	3,038,600.00
210702	Дотоод албан томилолт	6,122,200.00	3,038,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	181,169,391.00	269,809,637.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	179,360,291.00	268,046,137.00
210803	Даатгалын үйлчилгээ	900,000.00	750,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	214,000.00	214,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	54,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	421,100.00	744,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	170,872,941.31	347,874,238.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	94,147,304.01	295,027,065.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	57,002,649.99	33,617,485.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,722,987.31	19,229,688.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,917,166.00	5,946,851.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	25,684,800.00	1,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,820,000.00	1,400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	232,366.00	4,546,851.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-16,536,908.31	-17,892,836.22
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-16,536,908.31	-17,892,836.22

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	601,757,700.00	1,252,217,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	601,757,700.00	1,252,217,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	125,373,100.00	735,336,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,500,000.00	526,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,700,000.00	208,700,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,047,500.00	636,000.00
1330	Төсвийн захирагчдаас	476,384,600.00	516,881,900.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	476,384,600.00	516,881,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	601,525,334.00	1,247,671,049.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	601,525,334.00	1,247,671,049.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	575,993,834.00	1,246,271,049.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	173,525,753.00	595,331,068.00
210101	Үндсэн цалин	122,890,917.35	136,916,830.00
210102	Нэмэгдэл	44,520,836.00	32,598,389.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,113,999.65	5,426,000.00
210104	Урамшуулал	00.00	420,389,849.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,762,700.00	22,141,600.00
210201	Тэтгэврийн даатгал	16,721,900.00	15,166,622.23
210202	Тэтгэмжийн даатгал	1,760,200.00	1,753,626.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,408,200.00	1,458,880.95
210204	Ажилгүйдлийн даатгал	352,000.00	346,489.09
210205	Эрүүл мэндийн даатгал	3,520,400.00	3,415,981.55
2104	Хангамж, бараа материалын зардал	26,633,712.00	24,877,100.00
210401	Бичиг хэрэг	1,940,900.00	1,447,600.00
210402	Тээвэр, шатахуун	17,661,000.00	16,694,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,415,112.00	6,122,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	196,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	416,700.00	416,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,800,000.00	1,410,000.00
210604	Урсгал засвар	1,800,000.00	1,410,000.00
2107	Томилолт, зочны зардал	6,181,822.00	3,038,600.00
210702	Дотоод албан томилолт	6,181,822.00	3,038,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	184,449,647.00	270,352,971.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	182,261,647.00	268,581,971.00
210803	Даатгалын үйлчилгээ	900,000.00	750,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	214,000.00	214,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	54,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	800,000.00	752,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	159,331,900.00	329,119,710.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	95,000,000.00	295,355,410.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	64,331,900.00	33,764,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,531,500.00	1,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,531,500.00	1,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,666,700.00	1,400,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0,0	0,0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0,0	0,0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	169,177,150.00	4,278,070.00	7,243,139,968.00	7,416,595,188.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-13,248,000.00	-13,248,000.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	169,177,150.00	4,278,070.00	7,229,891,968.00	7,403,347,188.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-560,010,877.94	-560,010,877.94
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	169,177,150.00	00.00	-54,122,535.46	115,054,614.54
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	169,177,150.00	00.00	-54,122,535.46	115,054,614.54
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	169,177,150.00	00.00	-54,122,535.46	115,054,614.54
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-17,892,836.22	-17,892,836.22
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	169,177,150.00	00.00	-72,015,371.68	97,161,778.32

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	516,881,900.00	516,009,871.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	516,881,900.00	516,009,871.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	515,315,200.00	514,609,871.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	181,602,700.00	182,161,400.00
210101	Үндсэн цалин	137,319,000.00	136,916,830.00
210102	Нэмэгдэл	41,405,700.00	32,598,389.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,878,000.00	5,426,000.00
210104	Урамшуулал	00.00	7,220,181.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,380,300.00	22,141,600.00
210201	Тэтгэврийн даатгал	15,764,000.00	15,166,622.23
210202	Тэтгэмжийн даатгал	1,916,000.00	1,753,626.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,705,000.00	1,458,880.95
210204	Ажилгүйдлийн даатгал	363,200.00	346,489.09
210205	Эрүүл мэндийн даатгал	3,632,100.00	3,415,981.55
2104	Хангамж, бараа материалын зардал	24,881,300.00	24,877,100.00
210401	Бичиг хэрэг	1,447,600.00	1,447,600.00
210402	Тээвэр, шатахуун	16,694,400.00	16,694,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,122,600.00	6,122,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	196,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	416,700.00	416,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,410,000.00	1,410,000.00
210604	Урсгал засвар	1,410,000.00	1,410,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,038,600.00	3,038,600.00
210702	Дотоод албан томилолт	3,038,600.00	3,038,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	230,641,000.00	230,620,171.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	228,866,700.00	228,849,171.00
210803	Даатгалын үйлчилгээ	750,000.00	750,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	214,000.00	214,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	752,000.00	752,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50361300.00	50361000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,900,000.00	32,899,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,461,300.00	17,461,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1566700.00	1400000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,566,700.00	1,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,566,700.00	1,400,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00.00	516,009,871.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	516,009,871.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	13.00	14.00
620001	Удирдах ажилтан	02.00	02.00
620002	Гүйцэтгэх ажилтан	09.00	09.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	03.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	125,373,100	731,661,178.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	125,373,100	731,661,178.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0,0	731,661,178.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0,0	413,169,668.00
210104	Урамшуулал	0,0	413,169,668.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	125,373,100	39,732,800.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	125,373,1000	39,732,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		278758710.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	80,000,000	262,455,710.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	45,373,100	16,303,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	125,373,100	731661178.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	125,373,100	731,661,178.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	115,625,600	522,325,178.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,700,000	208,700,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,047,500	636,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь "Нутгийн өөрөө удирдах байгууллагын тогтвортой байдлыг төлөвшүүлж, хүний хөгжлийг хангасан "Стандарттай Ховд" хөтөлбөрийг дэмжиж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэн, ажиллаж амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд оршино" гэсэн эрхэм зорилтын дор стратегийн дараах 9 зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ. Үүнд:

- Аймаг, сумдын ИТХ, багийн ИНХ-ын үйл ажиллагааны үр нөлөө, үр өгөөжийг тогтвортой дээшлүүлэх, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлыг үнэлж дүгнэх, мэргэжил аргагүйгээр хангах журмыг шинэчлэн мөрдөж хэрэгжилтийг ханган ажиллах

- Хүний хөгжлийг хангасан, "Стандарттай Ховд" хөтөлбөрийн хүрээнд аймгийн эдийн засаг, нийгмийн олон тулгуурт ногоон эдийн засагт түшиглэсэн, бүс нутгийн үр ашигтай хамтын ажиллагааг эрхэмлэсэн, үйлдвэрлэл, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, эдийн засгийн өсөлтийг хангах хөгжлийн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх

- Аймгийн эдийн засгийн өсөлтийг хангаж хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүний хөгжлийг дэмжих замаар амьдралын чанарыг сайжруулах

- Орон нутгийн өмчийн харилцааг боловсронгуй болгож үр ашгийг дээшлүүлэх

- НӨУБ-ын сонгуультаан, ажилтнуудын манлайллыг хангаж, хүний нөөцийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх

- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль болон үзэл баримтлалыг сурталчлан таниулах

- Иргэд олон нийтийг идэвхжүүлж, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлж Төр-Иргэний хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үүрэг, итгэлцэл, ойлголцлыг нэмэгдүүлэх

- НӨУБ-ийн санхүүгийн чадавхыг бэхжүүлэх, санхүүгийн ил тод байдлыг хангах

- Аймгийн ИТХ-ын үйл ажиллагаанд Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг үе шатгүйгээр нэвтрүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, төрийн хэмнэлтийн тухай хууль болон түүнийг дагалдаж гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 4 удаа, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 1 удаа, Төсвийн тухай хуульд 6 удаа, Шилэн дансны тухай хуульд 1 удаагийн өөрчлөлт орж Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдан мөрдөгдөж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад санхүүгийн тайлан гаргахын өмнө тооцоо тооллого хийж, хяналт тавин ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17.9 сая төгрөгөөр буюу 12.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	175.8	131.9	(43.9)
Бараа материал	17,760	19,138	(1,379)
Үндсэн хөрөнгө	97,121	77,892	19,230
Нийт хөрөнгө	115,057	97,161	17,896
Өр төлбөр	2.20	0,0	(2,20)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	115,055	97,162	17,896
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	115,057	97,161	17,896

Дээрх хүснэгтээс харахад Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17.8 сая төгрөгөөр буурсанд материаллаг нөлөө үзүүлж байгаа данс нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна.

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Авлага дансны оны эцсийн үлдэгдэл 0,1 сая төгрөгийн авлага нь бусдаас авах тооцооны авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулсан байна.
- ✓ Бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 1.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 75.1 сая төгрөгийн бараа материал худалдан авч 73.7 сая төгрөгийн бараа материалын зарлага гаргаж оны эцэст бусад хангамжийн материал 18.0 сая, аж ахуйн материал 1.0 сая төгрөг, нийт эцсийн үлдэгдэл 19.1 сая төгрөг болсонтой холбоотой байна.
- ✓ Үндсэн хөрөнгө данс 19.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант үндсэн хөрөнгөд хөдөлгөөн ороогүй бөгөөд элэгдлийн зардал 19.2 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тус байгууллагын 2022 оны төсвийн төслийг цалин хөлс нэмэгдсэн, бараа материалын үнийн өсөлттэй уялдуулан, эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 557.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 40.4 сая төгрөгөөр бууруулж 516.8 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлангийн хугацаанд тухайн байгууллага нь орон нутгийн төсвөөс 516.8 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 516.8 сая төгрөгийн зардал санхүүжүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансанд цагаатгалын нөхөн олговор 160.0 сая төгрөг, Хөшөөт хөгжил сангаас 561.8 сая төгрөг, Аймгийн Засаг даргын захирамжаар ЗДТГ-аас 13.6 сая төгрөг нийт 735.2 сая төгрөгийн санхүүжилт олгож 731.6 сая төгрөгийг санхүүжүүлэн 3.6 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Д.Балжинням 2022 оны 02 дугаар сарын 15-аас 02 дугаар сарын 20-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар, аудитын менежер А.Цэцэгсүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2/18 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 617.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 12.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9.8 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2 - 15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1. Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт .

1.Аймгийн Засаг даргын 2022 оны А/695 тоот “хөрөнгө оруулалтын эрх шилжүүлэх тухай” захирамжаар ИТХ-ын нэмэлт дансанд иргэдийн төлөөлөгчдийн төлөөлөгчдийг мэргэшүүлэх хөтөлбөр арга хэмжээний зардал 80.0 сая төгрөгийн санхүүжилтийн эрх олгогдож, ИТХ-ын даргын захирамжаар нэр бүхий төлөөлөгч нарт 43.5 сая төгрөгийн гадаад улсад туршлага судлах сургалтад хамрагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.2.6 -д “Засгийн газар, Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийн төсөл дэх төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд хамаарах өөрчлөлт нь энэ хуульд заасан төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шаардлагыг хангасан байх”, 29¹.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна “ гэсэнтэй нийцэхгүй байна.

2. ИТХ-ын үйл ажиллагааны чиг үүрэгт хамааралгүй иргэдийн хуралд суудалтай намуудад санхүүгийн дэмжлэг олгох санхүүжилтийг бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн дансанд баталж өгч байгаа нь төсвийн төслийн шаардлага, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн, тухайн байгууллагын санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ болж, төсвийн төлөвлөлт, төсвийн ангилал, төсвийн зарчмуудтай нийцэхгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1. -д “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 22.6.5-д “төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн төвлөрүүлэн захирагч бүрээр, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагдахгүй төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах; гэсэнтэй нийцэхгүй байна.

4.4.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 172 мэдээллээс хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 170 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тухайн байгууллагад үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож ажиллах Засгийн газрын 43 дугаар тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангагдаагүй, холбогдох хууль, журамд нийцээгүй зардал санхүүжүүлсэн зэрэгтэй холбоотой зөрчлүүдэд албан шаардлага, зөвлөмж өгөгдсөнийг тайлант онд 50 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	18.2	0	0	0
Зөвлөмж	3	5.3	3	5.3	100
Нийт дүн	4	23.5	3	5.3	50

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ИТХ-ын үйл ажиллагааны чиг үүрэгт хамааралгүй иргэдийн хуралд суудалтай намуудад санхүүгийн дэмжлэг олгох санхүүжилтийг бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн дансанд баталж өгч байгаа нь төсвийн төслийн шаардлага, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн, тухайн байгууллагын санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэх ажил

гүйлгээ болж байгаа тул төлөвлөлтийг анхаарах, тээвэр шатахууны зарцуулалтад хэмнэлт үүссэн эсэх талаар анхаарч үзэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар байгууллагын ирүүлсэн санхүүгийн тайланд 7.2 сая төгрөгийн залруулга хийх алдаа¹ илэрлээ.

5.1 Залруулсан алдаа

Аудитын явцад санхүүгийн тайланд бусдаас авах тайлант онд хэрэгжээгүй төсөл арга хэмжээний 3.6 сая төгрөгийн санхүүжилтийн авлага, бусдад өгөх 3.6 сая төгрөгийн өглөгийн бүртгэлийг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахгүй байгаа тул залруулга хийж тухайн байгууллагаас албан тоот авч баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 134.1 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 2 алдаа зөрчилд 23.3 сая төгрөгийн төлбөрийн акт, 110.8 сая төгрөгийн 4 зөвлөмж өглөө.

5.2 Төлбөрийн акт

- *Иргэдийн төлөөлөгчийн хурлын төлөөлөгч нарт 22.6 сая төгрөгийн улирлын урамшууллыг Засгийн газрын тогтоол зөрчин илүү олгосон зөрчил дутагдал илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д " төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Засгийн газрын 404 тоот тогтоолоор "ИТХ-ын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах" журамд заасан заалтуудтай тус тус нийцээгүй байна.*
- *Нэр бүхий албан хаагч нарт хөдөө орон нутагт ажилласан томилолтын зардлыг давхардуулан илүү олгосон зөрчил дутагдал илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцээгүй байна.*

5.4 Зөвлөмж

5.4.1 Тээвэр шатахууны зардалтай холбоотой

Илрүүлэлт: Байгууллагын чиг үүргийн бус үйл ажиллагаанд 1.4 сая төгрөгийн шатахуун олгосон, тээвэр шатахууны зардалд 16.6 сая төгрөгийн зардал батлагдаж гүйцэтгэлээр 23.1 сая төгрөгийн зардал санхүүжүүлж батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулаагүй, шатахууны замын тооцооны хуудас шаардлагад нийцээгүй зэрэг зөрчил дутагдал илэрсэн нь тээвэр шатахууны зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.1-д " төсвийг үр ашигтай,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, гэсэн заалтуудтай тус тус нийцээхгүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.

5.4.2. Анхан шатны баримтын бүрдүүлэлт

Илрүүлэлт: Харилцагч байгууллагатай гэрээ хэлцлийн хүрээнд Ховд аймгийн Шүүхийн байранд Гэрээг цахим систем суурилуулах ажлын зардал, ГХУССЗ-ийн мэдээлэл сурталчилгааны зардалд /Цагдаагийн газарт/ шилжүүлсэн зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу, Хөшөөт хөгжил сангийн санхүүжилтээр “ Гурван сэнхэр төвтэй таван од аялал жуулчлалын хөтөлбөрийн хэрэгжүүлэлтийг эрчимжүүлэх” төсөл арга хэмжээний хүрээнд аймгийн аялал жуулчлалын анхдугаар чуулганы үйл ажиллагааны зардлын батлагдсан төсвийн гүйцэтгэлийн анхан шатны баримт дутуу, үр дүнгийн тайлан байхгүй, төсөл хөтөлбөрийн хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүн үзүүлэх зорилгоо хангахгүй байгаа зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 зүйлийн 4.1.16.-д “хөтөлбөр” гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг”, Нягтлан болох бүртгэлийн тухай хуулийн 13.7.-д “ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэнтэй нийцээгүй, сангийн хөрөнгийн үр ашгийг бууруулж байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган төсөл хөтөлбөр арга хэмжээний үр дүн, үр ашгийг дээшлүүлэн ажиллах

5.4.3. Батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах

Илрүүлэлт: Хөшөөт хөгжил сангийн батлагдсан хөтөлбөр арга хэмжээний зардлаас үндсэн үйл ажиллагааны зардал санхүүжүүлж, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулаагүй зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.1-д “ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, гэсэн заалтуудтай тус тус нийцээхгүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.

5.4.4. Төлөөлөгчийн зардал данстай холбоотой

Илрүүлэлт: Төлөөлөгчийн тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг тухайн жилийн төсвийн төсөлд нэг төлөөлөгчид 2.0 сая төгрөгөөр тооцож нийт 82.0 сая төгрөгийн зардлыг төсвийн төсөлд тусгаж, зардлын хязгаарт багтаан зарцуулах,

тайлагнах, үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг тухайн шатны Хурлын төсвийг захиран зарцуулах эрх бүхий төсөв захирагч хэрэгжүүлнэ гэснийг зөрчин анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад 68.1 сая төгрөгийн зардлыг тухайн харилцагч байгууллагад бус төлөөлөгч нарын хувийн харилцах данс руу шилжүүлж байгаа зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолын 3.8-д “Төлөөлөгчийн зардлыг бэлнээр олгохгүй бөгөөд үнийн нэхэмжлэх болон бусад баримтыг үндэслэн зардлын хязгаарт багтаан холбогдох санхүүжилтийг тухайн байгууллагад шилжүүлнэ” гэсэн заалтуудтай тус тус нийцээхгүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдээдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж зардлыг харилцагч байгууллага, аж ахуйн нэгжийн дансанд шилжүүлж Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл нэгтгэл / сая төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Залруулга	2	7.2	2	7.2	2	7.2
ДҮН	2	7.2	2	7.2	2	7.2

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл / сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төлөөлөгчийн урамшуулал илүү олгосон	1	22.6	1	22.6				
Томилолтын зардал давхардуулан олгосон	1	0,768	1	0,768				
Батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулаагүй,	1	7.9			-	-	1	7.9
Төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн анхан шатны баримт дутуу, үр дүнгийн тайлан байхгүй	1	32.0					1	32.0
Хөшөөт хөгжил сангийн батлагдсан хөтөлбөр арга хэмжээний зардлаас үндсэн үйл ажиллагааны зардал санхүүжүүлсэн	1	2.8	-	-			1	2.8
Засгийн газрын тогтоолын хэрэгжилт ханган ажиллаагүй	1	68.1					1	68.1
Дүн	6	134.1	2	23,3	-	-	4	110.8

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН

АУДИТОР:

Д.БАЛЖИННЯМ

